



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/117

Чингис хот

Шар усны аюулаас урьдчилан сэргийлэх  
нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.13 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн ихэнх нутгаар 2020-2021-ний өвөл цас их хэмжээгээр орж цаг агаарын дулаарлын явцад шар усны үерийн аюул тохиох, иргэд явганаар болон тээврийн хэрэгсэлтэй гол, нуурын мөсөөр зорчин цөмрөх эрсдэл өндөр байгаа тул "Шар усны аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ"-г зохион байгуулсугай.

2. Шар усны аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, шаардагдах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээнд шаардагдах 750.000 /долоон зуун тавин мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямд аваа/-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/, Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа /Ж.Эрдэнэбат/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010217

Аймгийн Засаг даргын 2021 оны  
...08 дугаар сарын...01 өдрийн ...А/117  
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ШАР УСНЫ АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЭГДСЭН  
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн  
ахлагч

Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх  
тасгийн дарга, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч

Гишүүд:

Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга

Онцгой байдлын газрын Ангиллын сургалт сурталчилгаа,  
урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн

Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын  
ахлах байцаагч, байцаагч

Байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч

Цаг уурын ажилтан, харуул

"Харгуй" ТӨХК-ны ерөнхий инженер

"Хэнтий Ус" ТӨХК-ны инженер

## ШАР УСНЫ АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

### Нэг. Зорилго

Хэнтий аймгийн ихэнх нутгаар 2020-2021-ний өвөл цас их хэмжээгээр орж цаг агаарын дулаарлын явцад цас хайлж, гол мөрөн, нуурын мөсний нягт эрчимтэй багасаж байгаа энэ үед иргэд явганаар болон тээврийн хэрэгслэлтэй гол, нуурын мөсөөр зорчиж цөмрөх, шар усны үерийн аюулд өртөх магадлал өндөр байна.

Иймд шар усны аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж ард иргэдийн аюулгүй байдлыг хангуулан сэрэмжлүүлэхэд оршино.

### Хоёр. Ерөнхий зүйл

Гамшгаас хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоол, Улсын их хурлын 2011 оны 22 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн “Шар усны аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”, Ус цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ, мэдээлэл эрх зүйн үндэслэл болно.

### Гурав. Хугацаа хамрах хүрээ

“Шар усны аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-г орон нутгийн онцлогт тохируулан 2021 оны 2 дугаар сарын 20-ны өдрөөс 2021 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулж илтгэх хуудсыг гэрэл зургийн хамт Онцгой байдлын газрын Ангиллын сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн хошууч Ө.Ганзоригт [/ganzorigulziiitogtoh@gmail.com/](mailto:ganzorigulziiitogtoh@gmail.com) хаягаар болон албан бичгээр 2021 оны 4 дүгээр сарын 16-ны дотор ирүүлнэ.

### Дөрөв. Зохион байгуулагдах үйл ажиллагааны чиглэл

Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг тухайн шатны Засаг даргын захирамжаар томилох.

Цаг агаарын мэдээг орон нутгийн хэмжээнд нарийвчлан тодруулж, гар усны үер, гол нуурын мөс цөмрөхөөс урьдчилан сэргийлэх мэдээг иргэд, малчид, аж ахуйн нэгж байгууллагад хүргэх, “Багц мессеж”-ээр хүргэх

Гол, мөрөн, нуурын арал, тохой, эрэг дагуу болон уулын ам бэл, жалга, сувгийн ойролцоох айл өрхийн судалгааг гарган сэрэмжлүүлгийг хүргэн шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх

Үерийн хамгаалалтын далан, зам гүүрний ус зайлуулах зориулалтын инженерийн байгууламжид үзлэг, шалгалтыг зохион байгуулж далан, суваг, шуудууны цэвэрлэгээг хийх

Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлийг ашиглан жолооч, малчид, иргэдэд гол, нуурын усан дээгүүр зорчихгүй байх сэрэмжлүүлгийн хүргэн баталгаагүй гарц, гарам хэсэгт анхааруулах самбар байршуулах

Болзошгүй аюулт үзэгдэл, гамшиг, ослын үед ажиллах хүн хүч, техник хэрэгслэлийг томилгоожуулан бэлэн байдлыг хангуулах

Сум орон нутаг, баг хороонд 2-оос доошгүй удаа өдөрлөг, ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулах

Орон нутгийн вэйб, фэйсбүүк хуудсанд урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байгаа талаарх мэдээллийг байршуулж ард иргэдэд хүргэх

**Тав. Нэгдсэн арга хэмжээний дүн, зардал**

Онцгой байдлын газрын Урьдчилан сэргийлэх тасаг удирдамийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлыг тухай шатны Засаг даргын гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлнэ.

Аймгийн Засаг даргын 2021 оны  
 03 дугаар сарын 01 өдрийн А/117  
 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

### ЗАРДЛЫН ТООЦОО

| д/д | Хийгдсэн ажил                                                                        | Нэр төрөл                                            | Мөнгөн дүн     |
|-----|--------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------|----------------|
| 1   | Үер ус зайлуулах далан, суваг, шуудууг шалгах                                        | А-80 шатахуун<br>30 л                                | 50,000         |
| 2   | Үерийн ус зайлуулах далан, суваг, шуудууны хогийг цэвэрлэх, зөөх асгах               | А-80 шатахуун<br>60 л                                | 100,000        |
| 3   | Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд /шторк, гарын авлага хэвлэмэл хуудас, багц мессеж/ | Шторк-100000                                         | 600,000        |
|     |                                                                                      | Хэвлэмэл хуудас тараах материал<br>500x300 =150000   |                |
|     |                                                                                      | Багц мессеж 2 удаа<br>8400x30=250000                 |                |
|     |                                                                                      | Баталгаагүй зам гарцын тэмдэглэгээ<br>4x25000=100000 |                |
|     | <b>Дүн</b>                                                                           |                                                      | <b>750,000</b> |